



ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2021 оны 43 болон 44 дахь долоо хоног

ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2021 оны 12-р сарын 24-ний байдлаар

Ковид-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулахад улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас 2 долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн 2021 оны 19 дэх дугаарыг хүргэж байна. Энэ удаагийн глобал эдийн засагт гарч буй өөрчлөлтийн тойм танилцуулгад i) Омикрон вирусын хувилбар, түүний эдийн засагт үзүүлж буй нөлөө ii) БНХАУ-ын үл хөдлөх салбар, түүний эрсдэл iii) Түүхий эдийн зах зээлд гарсан өөрчлөлтийн тухай тус тус тоймлон эмхэтгэв.

1

ОМИКРОН ВИРУСЫН ХУВИЛБАР, ТҮҮНИЙ ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

- Цар тахлын Омикрон вирусын хувилбар Өмнөд Африк Улсад нэг сар хүрэхгүй хугацааны өмнө анх бүртгэгдсэн талаар Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас мэдээлж байсан бол одоо тус хувилбар олон улс орнуудад хурдтай тархаж, Их Британи, АНУ, Өмнөд Африк, Энэтхэг, Норвеги, Дани зэрэг улсуудад цар тахлын давамгайллагч хувилбар болоод байна. Их Британийн эрдэмтдийн тооцооллоор вирусын тархалт 2-3 өдөрт 2 дахин нэмэгдэж, 1 халдвар дор хаяж 3 хүнд тархаж байгаа нь вакцин гарахын өмнөх дельта вирусын тархалттай төстэй байгаа талаар мэдээлэв. Хэдийгээр уг хувилбараар халдвар авсан хүмүүсийн хүндрэх магадлал өмнөх хувилбаруудаас бага гэж шинжээчид үзэж байгаа хэдий ч тархалт хурдтай байгаа нь эрүүл мэндийн салбарын ачааллыг өсгөх дарамттай байна. Ийнхүү Евро бүсэд цар тахлын Омикрон

вирусын шинэ давалгаа эрчээ авч байгаа тул тус бүсийн улс орнууд олон улсын нислэгээ хязгаарлах, дотооддоо тодорхой хэмжээнд хөл хорио тогтоох зэрэг арга хэмжээ авч эхэллээ. Харин вакцины хүрэлцээ улс орнуудад тэгш бус, 3 дахь тунд хамрагдсан хувь бага хэвээр байгаа¹ нь омикрон хувилбар хурдтай тархах нөхцөл болж байна. Модерна вакцин үйлдвэрлэгчийн судалгаагаар тус вакцины эхний 2 тун Омикрон вирусын халдварыг саармагжуулах эсрэг биеийн түвшинг 2.9 дахин нэмэгдүүлдэг бол Модерна вакцины 3 дахь (хагас) тун нь уг эсрэг биеийн түвшинг 37 дахин нэмэгдүүлдэг болохыг зарлаад байна. Үүнтэй төстэй ч шууд харьцуулагдах боломжгүй судалгаагаар Файзер/БионТек вакцины 3 дахь тун нь Омикрон хувилбарын халдварыг саармагжуулах эсрэг биеийн түвшинг 25 дахин нэмэгдүүлдэг

¹ Our world in data нэгдсэн портал дээрх мэдээллээр 2021 оны 12-р сарын 22-ны байдлаар КОВИД-19-ийн эсрэг вакцины 3 дахь тунд хамрагдсан байдал Европт нийт хүн амын 19.1

хувь, АНУ-д 18.3 хувь, Азид 3.8 хувь, Өмнөд Америкт 10.3 хувь, Австралид 5.5 хувь, дэлхийн хэмжээнд нийт хүн амын 5.5 хувийг тус тус байна.



болохыг тус байгууллагаас зарлаад байна.

- Евро бүсийн улс орнууд хөл хорио тогтоож эхэлсэн нь хүлээлтэд сөргөөр нөлөөлж, бүсийн эдийн засгийн идэвхжил болон хөрөнгийн үнэлгээ буурч эхэллээ. Тухайлбал, Евро бүсийн үйлчилгээний салбар агшсанаар бүсийн борлуулалтын менежерүүдийн индекс 11-р сард 55.4 байсан бол 12-р сард 53.4 болж буурлаа. Европын хөрөнгийн бирж дэх Евро Сток 600 индекс 12-р сарын 20-ны байдлаар өмнөх сарын мөн үеэс 3.8 хувиар унаад байна.
- БНХАУ-д 12-р сарын 14-нд Омикрон вирусын хувилбарын анхны зөөвөрлөгдсөн тохиолдол бүртгэгдэж, тухайн тохиолдол илэрсэн Тяньжин мужийн 10000 иргэн хөл хорионд орж, үйлдвэрүүд түр зогслоо. Тус улс Тэг-КОВИД бодлогыг хатуу хэрэгжүүлж байгаа учраас Омикрон вирусын хувилбар дотоодод тархаж эхэлбэл хөл хорио улам чангарч, энэ нь дэлхийн нийлүүлэлтийн гинжин сүлжээний доголдлыг улам хүндрүүлж, БНХАУ-ын болон Азийн бүсийн эдийн засгийн сэргэлтэд сөргөөр нөлөөлж болзошгүйг шинжээчид анхааруулж байна.
- Блүүмберг агентлагаас өндөр давтамжтай олон зуун статистик өгөгдөлд суурилан шинэчилсэн богино хугацааны төсөөллийн дагуу дэлхийн эдийн засаг оны 2021 оны 4-р улиралд 0.7 хувиар өсөх төлөвтэй байна. Омикрон вирусын хувилбарын тархалттай холбоотойгоор ийнхүү дэлхийн эдийн засгийн өсөлт өмнөх улирлаас 2 дахин саарахаар байна. Голлох улс орнуудыг авч үзвэл 4-р улиралд Евро бүс 0.8 хувиар, АНУ 1.2 хувиар, БНХАУ 4.5 хувиар тус тус өсөхийг өндөр давтамжтай тоон үзүүлэлтүүд зааж байгаа нь өмнөх улирлаас муудсан төлөв болно. Түүнчлэн, Бразил, Энэтхэг, ОХУ, Өмнөд

Африк зэрэг эрчимтэй хөгжиж буй орнуудын өсөлтийн төлөв өмнөхөөс буурлаа.

- Маккензи байгууллагын 12-р сарын 21-ний байдлаарх олон улсын гүйцэтгэх удирдлагуудын дунд явуулсан түүвэр судалгаагаар ирэх оны эдийн засгийн төсөөлөл өөдрөг байна. Судалгаанд оролцогчдын дийлэнх (57 хувь) нь ирэх 6 сарын хугацаанд дэлхийн болон улс орнуудын эдийн засаг сайжрахаар хүлээж байгаа боловч цар тахлын сүүлийн үеийн нөхцөл байдлаас шалтгаалан өмнөх (буюу 10-р сарын) түүвэр судалгаатай харьцуулахад өөдрөгөөр төсөөлж буй оролцогчдын хувь буурчээ. Судалгаанд оролцогчид өмнөх улирлуудын адилаар цар тахал бол дотоод эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж болзошгүй хамгийн том эрсдэл гэж харж байна. Цар тахлын дараагийн эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж болзошгүй эрсдэл бол инфляц гэж судалгаанд оролцогчид тодорхойлж байна.
- Омикрон вирусын тархалт инфляцыг нэмэгдүүлж болзошгүйг шинжээчид анхааруулав. Цар тахлын эхний үеүдэд улс орнууд хөл хорио тогтоон, ажил эрхлэлт, хэрэглээ огцом буурч, үнэ унаж байв. Харин одоо бизнес, иргэд цар тахлын нөхцөлд дасан зохицож, цар тахлын хэрэглээнд үзүүлэх нөлөө харьцангуй бага байх боловч Омикрон вирусын тархалт нэмэгдэх гол сөрөг нөлөө нь ажил эрхлэлтийн сэргэлтийг удаашруулж, нийлүүлэлтийг хязгаарлан, инфляцыг одоогийн өндөр түвшинд удаан хадгалах эсвэл улам өсгөх нөлөө үзүүлж болзошгүй байна. Олон улсын байгууллагууд Омикрон хувилбарын эдийн засагт үзүүлэх нөлөөг 1) улс орнуудын засгийн газрын хориг арга хэмжээ, 2) олон нийтийн болгоомжлол, 3) Засгийн газраас хувийн секторыг дэмжих чадамж, 4) Төв



банкуудын бодлогын төлөв зэргээс шалтгаална гэж үзэж байна.

Эх сурвалж:

1. The Economic Times, [Impact of Omicron on emerging economies to depend on restrictions, policy support: Moody's](#)
2. Our World in Data, [Share of people vaccinated against Covid-19](#)
3. Commons Library Research Briefing, [Coronavirus: Economic impact](#)
4. Bloomberg, [Omicron Set to Halve Fourth Quarter Global Economic Growth](#)
5. The Economist, [Omicron storms Europe](#)
6. The Economist, [Omicron latest: cases of the new variant are less severe than Delta, new studies say](#)
7. Focus Economics, [Euro Area: Business activity growth slows in December amid renewed restrictions](#)
8. McKinsey & Company, [The coronavirus effect on global economic sentiment, December 2021](#)
9. The Wall Street Journal, [Central Banks Worry Omicron Could Sustain Inflation](#)
10. Financial Times, [Moderna Covid booster produces strong antibody response against Omicron](#)


2 БНХАУ-ЫН ҮЛ ХӨДЛӨХИЙН САЛБАР, ТҮҮНИЙ ЭРСДЭЛ

БНХАУ-ын үл хөдлөх салбарын онцлог

- БНХАУ-ын эдийн засгийн дөрөвний нэгийг эзлэх үл хөдлөх салбар нь дэлхийн түүхий эдийн зах зээл, глобал эдийн засагт чухал ач холбогдолтой юм. БНХАУ-д санхүүгийн үүсмэл хэрэгслүүд төдийлөн сайн хөгжөөгүй тул үл хөдлөхийн салбар нь орон сууцны үүргээс гадна хөрөнгө оруулалтын чухал хэрэгсэл болдог. Тухайлбал, Америкт хотын өрхүүдийн 30 орчим хувь нь үл хөдлөхөд хөрөнгө оруулж байхад БНХАУ-д энэ нь 60 орчим хувьтай байна. Мөн орон нутгийн төсвийн орлогын дийлэнх (40 хувиас их) нь газрын борлуулалтаас хамаардаг тул орон нутгийн удирдлагууд нь үл хөдлөх бүтээн байгуулалтыг дэмжихэд онцгойлон анхаардаг.
- БНХАУ-ын үл хөдлөх салбарын 2000-2015 оны хурдацтай өсөлтүүд нь эдийн засгийн суурь хүчин зүйлсээс ихээхэн хамаарч байжээ. Тухайлбал, энэ хугацаанд бодит ДНБ 9.7 хувиар, бүтээмж 3.9 хувиар, хотын хүн ам 3.7 хувиар өссөн байхад үл хөдлөхийн үнэ

8.3 хувиар өссөн байна (Зураг 1). Харин 2015-2019 онуудад бодит ДНБ-ий 6.6 хувь, бүтээмж 2.7 хувь, хотын хүн ам 2.8 хувиар тус тус өсөж, өсөлт нь удааширсан үед орон сууцны үнэ 9.4 хувиар нэмэгджээ. Орон сууцны үнэ 2008-09 оны санхүүгийн хямралын дараагаас суурь хүчин зүйлсийн өөрчлөлтөөс давж өсөх эхлэл тавигджээ. Тодруулбал, дэлхийн санхүүгийн хямрал болоход БНХАУ-ын эрх баригчдын зүгээс эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор ихээхэн хэмжээний зээл олгож хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсэн бөгөөд энэ хугацаанд бүтээмжийн өсөлт буурч эхэлсэн юм. Өөрөөр хэлбэл, орон сууцны салбарын томоохон өсөлт нь суурь хүчин зүйлсээс хамаарч өсөхөөс илүүтэй БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийг дэмжих бодлогоос ихээхэн хамааралтай болсон байна.

Зураг 1. БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн үнийн өсөлт болон суурь хүчин зүйлсийн өөрчлөлт



Эх сурвалж: IHS Markit

Энэхүү бодлогын нөлөөнөөс шалтгаалж үл хөдлөхийн салбарын өр нэмэгдэж, томоохон корпорацууд нь өрөө төлөх чадамжгүй болсноос цаашид зөвхөн үл хөдлөх салбар төдийгүй санхүүгийн зах зээл, эдийн засгийн өсөлтөд томоохон эрсдэлийг дагуулаад байна. Тухайлбал, Холбооны нөөцийн банк 2021 оны 11-р сард гаргасан “Санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-даа БНХАУ-ын үл хөдлөх салбарт үүсээд буй хямрал нь дэлхийн санхүүгийн системээр дамжиж Америк төдийгүй дэлхийн эдийн засгийн өсөлтөд эрсдэл учруулаад байна гэж дурджээ.

БНХАУ-ын үл хөдлөх салбарын эрсдэл

- БНХАУ-ын үл хөдлөхийн үнэ, борлуулалт, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт зэрэг үзүүлэлтээс үзэхэд БНХАУ-ын үл хөдлөх салбар хямралд ороход тун ойрхон байна. Тухайлбал, энэ оны 11-р сард үл хөдлөхийн үнэ
- БНХАУ-ын томоохон үл хөдлөхийн корпорацуудын захирлууд нийт 46 тэрбум ам.долларын алдагдал хүлээгээд байна.

өмнөх сараас 0.3 хувиар буурсан нь Рөүтерс агентлагийн тооцооллоор 2015 оны 2-р сараас хойш хамгийн том уналт болжээ. Үл хөдлөхийн борлуулалт 5 сар дараалан буурч байгаа бөгөөд 11-р сард өмнөх оны мөн үеэс 16.3 хувиар унаад байна. Мөн шинээр барьж байгаа үл хөдлөхийн төслийн хэмжээ 11-р сард өмнөх оноос 21 хувиар агшиж, үл хөдлөхийн хөрөнгө оруулалт 4.3 хувиар буурав. Нэгтгэн дүгнэвэл БНХАУ-ын үл хөдлөхийн томоохон корпорацууд өр төлбөрөө барагдуулахад хүндрэлтэй тулгарч, зээлжих зэрэглэл нь буурч, БНХАУ-ын Ардын банкны зүгээс энэхүү нөлөөг зөөллөхөөр мөнгөний тэлэх бодлого баримталж байна.

Хүснэгт 1. БНХАУ-ын томоохон үл хөдлөх корпорацуудын захирлуудын алдагдал

Нэр	Компани	Өнөөгийн хөрөнгө	Оны эхнээс алдагдал хүлээсэн хэмжээ
Хуй Ка Ян	Evergrande	6.1	17.2
Ван Жианлин	Wanda	8.2	6.9
Ян Хуйян	Country Garden	23.7	6.3
Хуй Вин Мау	Shimao	4.4	5.2
Сун Хонбин	Sunac	3.3	4.5
Кей Хой Панг	Logan	5.2	3.2
Ву Яжун	Longfor	13.9	2.2
Кай Күй	Longfor	8.3	0.9
Нийт		73.1	46.4

Эх сурвалж: Блумберг тэрбумтнуудын индекс, 12-р сарын 15-ны өдрийн байдлаар

- Фитч агентлаг Эвергранд 12-р сарын 6-нд 82.5 сая ам.долларын купоны төлбөрөө төлж чадаагүй тул тус компанийн зээлжих зэрэглэлийг “хязгаарлагдмал дефолт²”, мөн БНХАУ-ын томоохон үл хөдлөх корпорацуудын нэг болох Кайса 12-р сарын 8-ны Лхагва гарагт 400 сая ам.долларын бондоо төлж чадаагүйгээс тус компанийн зээлжих зэрэглэлийг “Хязгаарлагдмал дефолт” болгон тус тус буурууллаа. Улмаар Кайсагийн хувьцааны үнэ 15.2 хувиар унаад байна.
- БНХАУ-ын Ардын Банкны зүгээс үл хөдлөх салбарт болж буй хямрал, үүнээс шалтгаалж удааширч буй эдийн засгийн идэвхлийг сэргээх зорилгоор 1 жилийн хугацаатай зээлийн хүүгээ энэ оны 12-р сард 3.85 хувиас 3.8 хувь болгож бууруулаад байна. Мөн заавал байлгах нөөцийн хувь хэмжээгээ бууруулснаар 1.2 их наяд буюу 188 тэрбум орчим ам.доллартай тэнцэх эх үүсвэр чөлөөлжээ. Харин 5 жилийн хугацаат зээлийн хүүг 4.65 хувьд хэвээр хадгаллаа. Шинжээчид БНХАУ-ын Ардын Банкаас баримталж буй мөнгөний зөөлөн бодлогын цар хүрээг харьцангуй бага хэмжээтэй хэмээн

дүгнэж байна. Тухайлбал БНХАУ-ын “Капитал Экономикс” судалгааны байгууллагын ахлах шинжээч Жулиан Эванс-Причард “зээлийн өсөлтийг хязгаарлах бодлогын арга хэмжээг эргэн харахгүйгээр зөвхөн төв банкны шийдвэр эдийн засгийн өсөлтийг дэмжихэд хангалтгүй” хэмээжээ.

Эх сурвалж:

1. Bloomberg, [Property Stocks Tumble; China Backs Deals: Evergrande Update](#)
2. IHS Markit, [The Evergrande Crisis and mainland China's property sector risks](#)
3. Xinhua Net, [China holds key economic meeting to plan for 2022](#)
4. The Wall Street Journal, [China Moves to Boost Slowing Economy](#)
5. Financial Times, [China easing fails to calm Evergrande jitters in property sector](#)
6. Financial Times, [China cuts lending rate as economic momentum falters](#)
7. Financial Times, [Evergrande rated 'restricted default' by Fitch after missed payment](#)
8. Financial Times, [China reports first Omicron case as fears mount for factory supply chains](#)

² Фитч агентлагаас “хязгаарлагдмал дефолт”-ын аж ахуй нэгжид бондын төлбөрөө төлөөгүй дефолт зарласан боловч дампуураагүй, татан

буулгагдаагүй аж ахуй нэгжийг хамруулж ойлгож байна.

3 ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙ

Коксжих нүүрсний зах зээл

- БНХАУ-ын мужуудад коксжих нүүрсний үнэ сүүлийн хоёр 7 хоногт тогтвортой байсан бол боомтууд дээрх коксжих нүүрсний үнэ нэмэгдлээ. Энэ оны 12-р сарын 17-ны байдлаар Хэбэй мужид 1 тонн коксжих нүүрсний үнэ өнгөрсөн хоёр 7 хоногтой адил түвшинд буюу 2660 юань буюу 417 орчим ам.доллар, Шанси мужид 2460 юань буюу 386 орчим ам.доллар байж тогтвортой байлаа. Харин Тяньжин боомтын эрэлт нэмэгдсэнээр 1 тонн коксжих нүүрсний үнэ өнгөрсөн 7 хоногт 50 юаниар, энэ 7 хоногт 80 юаниар тус тус нэмэгдэж 2830 юань буюу 444 орчим ам.долларт хүрээд байна.
- БНХАУ-ын Ардын Банкнаас заавал байлгах нөөцийн хувийг 12-р сарын 15-наас 0.5 нэгж хувиар бууруулж 8.4 хувь болгох шийдвэр гаргасан, орон сууцны зээлийн нөхцөлийг зөөллөсөн зэргээс шалтгаалж гангийн зах зээлийн хүлээлт сайжирч, гангийн үнэ нэмэгдэв. Үнэ өсөх нөлөөгөөр гангийн үйлдвэрлэгчдийн ашиг нэмэгдэж, үйлдвэрлэлээ нэмэгдүүлснээр гангийн үйлдвэрүүд коксжих нүүрсний нөөцөө нэмэгдүүлж эхэллээ.
- Сяой, Шаньсид 12-р сард тохиолдсон үерийн улмаас БНХАУ-ын нүүрсний уурхайнуудын хяналтыг чангалж, өндөр хүчин чадлаар ажиллах боломжийг хязгаарлав. Үүний нөлөөгөөр БНХАУ-ын дотоодын нүүрсний нийлүүлэлт буураад байна. SXcoal судалгааны байгууллагын судалгаанд хамрагдсан нүүрсний үйлдвэрүүдийн хүчин чадлын ашиглалт

өмнөх 7 хоногоос 1.6 хувиар буурч 103 хувьд хүрээд байна.

- БНХАУ-ын “Төвийн эдийн засгийн ажлын хурал 2022” Бээжин хотноо 12-р сарын 8- 10-нд боллоо. Энэхүү хуралд дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, “Нэг хот, нэг бодлого”-ын хүрээнд үл хөдлөх салбарын тогтвортой өсөлтийг дэмжих талаар ярилцсан нь цаашид гангийн эрэлтийг нэмэгдүүлэх хүлээлтийг үүсгэж байна. Гэвч 2022 оны 2-р сард болох өвлийн олимп, хүйтний улиралд гангийн үйлдвэрийг хязгаарлах болсноос шалтгаалж одоохондоо гангийн үйлдвэрлэл огцом нэмэгдэхээргүй байна.

Монголын нүүрсний экспорт

- Гашуунсухайт-Ганцмод боомтоор нэвтэрсэн ачааны машины хоногийн дундаж тоо 12-р сарын 18-ны байдлаар 85-д хүрч буураад байна. Хилээр нэвтрэх ачааны авто машины тоо огцом буурснаас шалтгаалж Монголын нүүрсний тус боомт дээрх үнэ 12-р сарын эхний долоо хоногоос 190 юаниар нэмэгдэж 1700 юань буюу ойролцоогоор 267.9 ам.долларт хүрээд байна.
- Шивээхүрэн-Сэхэ боомт хаалттай хэвээр байгаа бөгөөд тус боомт дээрх коксжих нүүрсний үнэ өмнөх 7 хоногоос өөрчлөгдөөгүй, 1550 юань буюу 243.1 орчим ам.доллар хэвээр хадгалагдав.

Хүснэгт 2. Экспортын гол нэрийн түүхий эдийн дэлхийн зах зээл дээрх үнийн өөрчлөлт

	Бодит гүйцэтгэл						Товч тайлбар
	Үнэ (\$) 2021/12/21	Өөрчлөлт					
		өдрийн	7 хоногийн	сарын	оны эхнээс	жилийн	
Зэсийн үнэ	9534	-0.9%	-1.3%	2.0%	21.3%	21.5%	Зэсийн үнэ 12-р сарын 22-ны байдлаар 9534 долларт хүрэв. БНХАУ-ын Ардын Банкнаас мөнгөний бодлогоо зөөллөсөн, цаашид нэмж зөөллөх хүлээлттэй байгаа тул зэсийн үнэ ийнхүү нэмэгдэв.
Төмрийн хүдрийн үнэ	113.8	-0.1%	6.2%	21.7%	-30.7%	-26.7%	Төмрийн хүдрийн үнэ 113.8 болж нэмэгдсэн бөгөөд энэ нь сүүлийн 2 сарын дээд цэгт хүрээд байна. БНХАУ-ын ардын банкаас мөнгөний бодлогоо зөөллөсөн, гангийн үйлдвэрүүд оны эцэс хүртэл гарцаа нэмэгдүүлэхээр болсон зэргээс шалтгаалж төмрийн хүдрийн үнэ ийнхүү нэмэгдэв.
Алтны үнэ	1790.1	-0.1%	-1.0%	-0.9%	-5.8%	-4.7%	12-р сарын 21-ны байдлаар алтны үнэ 1790 долларт хүрэв. Улс орнуудын Төв банкууд инфляцыг бууруулах зорилгоор бодлогын хүүгээ нэмэгдүүлж эхэлснээр алтны эрэлт, үнэ ийнхүү буурч байна.
Газрын тосны үнэ (Брент)	73.98	3.4%	0.4%	-7.2%	44.8%	45.3%	Газрын тосны үнэ 74 ам долларт хүрсэн нь өмнөх сараас 7.2 хувиар буурсан үзүүлэлт боллоо. КОВИД-19 цар тахлын шинэ хувилбар тархаж улс орнууд тээвэрлэлтийн хязгаарлалт тогтоогоод байгаагаас шалтгаалж газрын тосны эрэлт саарч, үнэ нь буурав. Харин ОПЕК-ийн зүгээс омикрон хувилбарын нөлөө богино хугацаанд үргэлжилж, төдийлөн хүчтэй нөлөө үзүүлэхгүй гэж мэдээлсэн.

Эх сурвалж:

1. *SX Coal, Weekly Update, Monday 13th Nov, 2021*

2. *SX Coal, Weekly Update, December 20th Nov, 2021*